

Н.ГЭРЭЛМАА, Ц.БАТТУЛГА*

РАШААН ХАДНЫ ТҮРЭГ БИЧЭЭСИЙН ТУХАЙ ДАХИН ӨГҮҮЛЭХ НЬ

Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт байх Рашаан хаднаа олон зүйл тамга, бичгийн дурсгалууд буйг нэрт түүхч Х.Пэрлээ 1974 онд хэвлүүлэн судалгааны эргэлтэд оруулсан¹ ажээ.

1979 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн "Бичээс" судлалын хэсэг руни бичгийн дурсгалыг тухайлан судалсан бөгөөд түрэг судлаач С.Харжаубай хожим судалгааны ажлынхаа үр дүнг нийтлүүлсэн байна. Тэрбээр Рашаан хаднаа руни бичгийн хоёр хэсэг дурсгал байна хэмээн үзэж "А" бичээс, "Б" бичээс хэмээн тэмдэглэн доорхи мэт тайлан уншжээ.

Үүнд: Бичээс "А": "atam aram adijun" буюу "Эцэг өвгөдийн шан хишиг

Бичээс "Б": "sat atič erti" буюу "Зеригтой ач хүү билээ" гэж галиглан орчуулсан буй². Түүнчлэн "А" бичээст буй "·᠋᠋" тэмдэгтийг эртний түргийн "᠋᠋" үсгийн ерөнхий зурлага болон Таласын зарим дурсгалд тохиолдох хэлбэр зэргийг нь харгалзан үзэж "m" хэмээн уншсанаа, мөн "·᠋᠋" үсэг зурлагын дараахи "1 /p/" үсгийг орхиж сийлснээ мөрийн доод талд хоёр "m" үсгийн дунд нохож сийлсэн болохыг онцлон тэмдэглэсэн байдаг³.

Бид Рашаан хадны руни бичгийн дурсгалыг хэдэн удаа очиж нягтласан бөгөөд өөрсдийн авсан хэв хуулбар, гэрэл зурагт түшиглэн дахин уншиж судалсан билээ. Бидний судалгаа С.Харжаубай гуайн дээрхи уншлага орчуулгаас нэлээд зөрүүтэй байгааг тэмдэглэе.

"А" бичээс хэмээгдэх нэг мөр руни бичгийн үсэг тэмдэгт хэн ч харам тодорхой байгаа бөгөөд харин "Б" бичээс харьцангуй тод бус, үсэг бичиг гэхээсээ илүүтэй үргэлжлүүлэн сийлсэн тамга хэмээн үзэлтэй байна. Учир нь, хэдийгээр төгсгөлийн гурван тэмдэгтийг ГhГ буюу arti хэмээн уншиж болох боловч Г тэмдэгт нь доороо хоёр хөндлөн зураастай, мөн бусад тэмдэгт ч үсэг гэж үзэх боломжгүй юм.

Рашаан хадны руни бичээсийн урт 22 см, үсгийн өндөр дундажаар 4 см бөгөөд нийт 8 үсэг тэмдэгтэй, нэг тэмдэгтийг доор нь нохож оруулсан байдалтай сийлсэн байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг:

᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋

1

* МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхимийн багш

МУИС, Түрэг судлалын товийн эрхлэгч

¹ Х.Пэрлээ, Дорнод монголын эртний үсэг бичгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэл), - Шинжлэх ухаан, амьдрал, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.

² С.Харжаубай, Монгол нутгаас олдсон эртний түрэг бичээсүүд, -Хэл зохиол, 16-р боть, 1-19 дэвтэр, Улаанбаатар, 1982, 83-84 дүгээр тал.

³ С.Харжаубай, Монгол нутгаас олдсон эртний түрэг бичээсүүд, -Хэл зохиол. 16-р боть, 1-19 дэвтэр, Улаанбаатар, 1982, 84 дүгээр тал.

Үсгийн галиг:

T N p m š ŋ W N

Үгийн галиг:

atan aram šaŋun

Орчуулга:

Алдаршсан өвөг мiнь Шанун

Бичээсийн 2, 3-р үсгийн дунд байгаа ганц цэгийг бид мөрийн доор бичигдсэн “т” буюу “р” үсгийг нөхөж оруулахыг илтгэсэн нэмэлт тэмдэгт хэмээн үзэж байна. С.Харжаубай гуайн тайлбарласанчлан “ш” буюу “м” үсгийн нэг хувилбар хэмээн үзвэл нэг бичээсийн нэг мөрөнд “т” үсгийг хоёр янзаар бичих нь учир дутагдалтай мэт санагдана. Нөгөө талаар руни бичгийн дурсгалд давхар цэгийг тусгаарлагчийн үүргээр хэрэглэдэгээс бус дан цэг тэр бүр тохиолддоггүй билээ. Иймээс уг ганц цэг нь ямар нэгэн нэмэлт үүргийг агуулж байж болох юм.

Монгол нутгаас олдсон руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалуудад “šaŋun-жанжин” хэмээх цол олонтоо тохиолддог билээ. Уул бичээсийг “šaŋun” цолтой нэгнийг үр ач нь алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор бичиж үлдээсэн бололтой.

Summary

Historian Kh.Perlee discovered many signs and inscriptions in Rashaan Khad, Batshireet sum, Khentii aimag. Before that it was reported that there were two runic inscriptions in Rashaan Khad. However, according to our research there is one inscription not two and the other inscriptions are different kinds of signs.

Origin of the inscription:

ᠲᠠᠨ ᠠᠷᠠᠮ ᠱᠠᠭᠤᠨ

1

Transliteration:

T N p m š ŋ W N

Transcription:

atan aram šaŋun

Translation



Our Renowned Ancestor Shanun

Номзүй

1. Х.Пэрлээ, Дорнод монголын эртний үсэг бичгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэл), - Шинжлэх ухаан, амьдрал, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.
2. С.Харжаубай, Монгол нутгаас олдсон эртний түрэг бичээсүүд, -Хэл зохиол, 16-р боть, 1-19 дэвтэр, Улаанбаатар, 1982, 83-84 дүгээр тал.



Рашаан хадны ерөнхий байдал



Рашаан хадны руни бичээс